

Төсөл

ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ЗАХИРАЛ, ДАРГА НАРТ

*Зөвлөх Батсүх
Болортуулсан*

Хуулийн төсөл хэлэлцүүлэх тухай

~~Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулан~~ Ус цаг уур, орчны хяналт, шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, уг хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хавсралтаар хүргүүлж байна.

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй танилцаж, хамт олноороо хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлгийн тэмдэглэл, оролцогчдын мэдээлэл, гарсан саналуудыг нэгтгэн 2026 оны 2 дугаар сарын 26-ны дотор албан тоотоор ирүүлнэ үү.

Хавсралт хуудастай.

ДАРГА,

ХУУЛИЙН АЖЛЫН ХЭСГИЙН ДЭД ДАРГА

Э.БАТТУЛГА

2026 оны сарын өдөр

Хянасан:

УАӨОШХ-ИЙН ДАРГА

У.Тал

Н.ГАЛЦОГ

2026 оны *02* сарын *10* өдөр

Боловсруулсан:

УАӨОШХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Орссан

С.ЭНХМАА

2026 оны *02* сарын *10* өдөр

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл, аюулгүй, орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм эдийн засгийг байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй уялдуулан хөгжүүлэх зорилгоор ус цаг уур, орчны хяналт шинжилгээг тогтмол хийж шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээ, мэдээллээр хүн хуулийн этгээд/цаашид "хэрэглэгч" гэх/-ийг шуурхай хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль тогтоомж

2.1.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Агаарын тухай хууль, Усны тухай хууль, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, энэ хууль, эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуульд зааснаас бусад уур амьсгалын хяналт шинжилгээтэй холбогдох харилцааг энэ хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“ус цаг уур” гэж ус судлал болон цаг уур судлалыг хамтад нь;

4.1.2.“цаг уур” гэж агаар мандлын төлөв байдал, агаар мандалд ажиглагддаг байгалийн үзэгдлийн хувьсал, өөрчлөлтийн үйл явцыг;

4.1.3.“ус судлал” гэж гол, мөрөн, горхи, булаг, суваг шуудуу, нуурын усны хувьсал, өөрчлөлтийн үйл явц, төлөв байдлыг;

4.1.4. "ус цаг уурын ажиглалт" гэж агаар мандал, гол, мөрөн, горхи, булаг, суваг шуудуу, нуурын усны хөдөлгөөн, хувьсал, өөрчлөлтийн үйл явц, үзэгдэл, төлөв байдлыг илэрхийлэх үзүүлэлтийн шууд болон шууд бус системтэй ажиглалт, хэмжлийг;

4.1.5. "урьдчилсан мэдээ" гэж тодорхой хугацааны туршид тухайн бүс нутаг, хот, суурингийн ус цаг уурын ирээдүйн төлөв байдал, хувьсал, өөрчлөлтийн үйл явц, үзэгдлийн талаар гаргасан мэдээ, мэдээллийг;

4.1.6. "сэрэмжлүүлэг" гэж ус цаг уур, орчны үзэгдэл нь хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд эрсдэл үзүүлж болзошгүй тухай урьдчилсан мэдээг;

4.1.7. "нийтийн хэрэгцээний мэдээ" гэж хүн амын өргөн хэрэгцээнд зориулан хэвлэл, мэдээллийн хэрэгслээр түгээн зарлаж байгаа ус цаг уур, орчны хяналт шинжилгээний мэдээг;

4.1.8. "тусгай хэрэгцээний мэдээ" гэж тодорхой салбарын онцлогийг харгалзсан хэрэглэгчийн захиалгаар гаргаж байгаа ус цаг уур, орчны мэдээг;

4.1.9. "ус цаг уурын гамшиг" гэж хүний амь нас, эд хөрөнгөд хохирол учруулж, хүрээлэн буй орчин, амьдралын нөхцөл байдал болон нийгэм-эдийн засгийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй ус цаг уурын онцгой үзэгдлийг;

4.1.10. "уур амьсгал" гэж цаг уурын үзүүлэлтүүдийн урт хугацааны статистик үзүүлэлтээр тодорхойлогдсон цаг агаарын төлөв, байдлыг;

4.1.11. "уур амьсгалын өөрчлөлт" гэж байгалийн хүчин зүйл болон хүний үйл ажиллагааны улмаас уур амьсгалын төлөв байдалд гарч буй урт хугацаанд үргэлжлэх өөрчлөлтийг;

4.1.12. "урт хугацааны урьдчилсан мэдээ" гэж уур амьсгалын ирээдүйн хандлага, одоогийн төлөв байдлын талаарх өгөгдөл, мэдээлэл болон сар, улирал, жилийн уур амьсгалын олон жилийн дунджаас хазайцаар илэрхийлэгдсэн мэдээллийг;

4.1.13. "уур амьсгалын өөрчлөлтийн хувилбар" гэж нийгэм-эдийн засгийн үйл ажиллагаа, хүлэмжийн хийн ялгарал, уур амьсгалын өөрчлөлт, далайн түвшний өсөлтийн хоорондын харилцан хамаарал дээр үндэслэсэн уур амьсгалын ирээдүйн хандлагын талаарх шинжлэх ухааны үндэслэлтэй таамаглалыг;

4.1.14. "уур амьсгалын өөрчлөлтийн хяналт шинжилгээ" гэж уур амьсгалын өөрчлөлтийн шинж тэмдэг, байгалийн нөөц, байгаль орчин, экосистем, хүн амын амьдрах орчин, нийгэм эдийн засгийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох зорилгоор урт хугацааны туршид хийж буй уур амьсгалын хэлбэлзэл, өөрчлөлтийг хянах, шинжлэх, үнэлэх, дүн шинжилгээ хийх, мэдээ, мэдээлэл цуглуулах үйл явцыг;

4.1.15. "ус цаг уурын шинжилгээний талбай" /цаашид "шинжилгээний талбай" гэх/ гэж ус цаг уурын ажиглалтыг техникийн стандартын дагуу явуулах, тухайн нутаг дэвсгэрийн байгалийн шинж чанарыг бодитойгоор илэрхийлэх, үндэсний болон олон улсын стандартад нийцсэн нарийвчлалыг хангах ус цаг уурын

ажиглалтын мэдээллийг цуглуулахад шаардлагатай газрын дээрх болон доорх орон зай, усны гадаргын болон ёроолын талбайг;

4.1.16. “агаарын төлөв байдал, цаг уурын үзэгдэлд зориуд нөлөөлөх” гэж шинжлэх ухаан, технологийн шийдлээр агаар мандлын физик, химийн процесст хүн нөлөө үзүүлэхийг;

4.1.17. “уур амьсгалын стандарт” гэж ус цаг уурын үзүүлэлтүүдийн тодорхой цаг хугацааны буюу ихэвчлэн 30 жилийн дундаж утгыг;

4.1.18. “орчны хяналт шинжилгээ” гэж хийн мандал, усан мандал, чулуут мандал, шим мандлын байгалийн чанар, төлөв байдлын үзүүлэлтүүдийг хэмжин тодорхойлж дүн шинжилгээ хийсний үндсэн дээр зохих шийдэл гаргах үйл ажиллагааг.

5 дугаар зүйл. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний зарчим

5.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтлана:

5.1.1. тогтмол, тасралтгүй, шуурхай, үнэн зөв байх;

5.1.2. шинжлэх ухаанд үндэслэх;

5.1.3. орчин үеийн дэвшилтэт техник, технологид тулгуурлах;

5.1.3. ажиглалт, хэмжилтийн мэдээ, мэдээлэл дотооддоо болон олон улсад харилцан солилцох боломжтой байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ УЛСЫН СҮЛЖЭЭ, ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГА

6 дугаар зүйл. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээ

6.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээ/цаашид “улсын сүлжээ” гэх/ нь ус цаг уур, уур амьсгалын өөрчлөлтийн ажиглалт, хэмжилт, орчны төлөв байдлыг системтэй, тогтвортой, тасралтгүй, байнга хийх зориулалт бүхий станцуудаас бүрдэнэ.

6.2. Улсын сүлжээг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага удирдлага арга зүйгээр хангана.

6.3. Улсын сүлжээний үйл ажиллагаатай холбогдох зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

7 дугаар зүйл. Улсын сүлжээний ерөнхий төлөвлөгөө

7.1. Улсын сүлжээний ерөнхий төлөвлөгөөг Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална.

7.2. Улсын сүлжээний ерөнхий төлөвлөгөөнд дараах зүйлийг тусгана:

7.2.1.гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хариу арга хэмжээ авахад шаардлагатай ус цаг уурын мэдээлэл, өгөгдлийг тодорхойлсон байх;

7.2.2.өмнөх ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ, ус цаг уурын ажиглалт, уур амьсгалын өөрчлөлтийн хяналт шинжилгээ, үнэлгээ;

7.2.3.ажиглах, хэмжих шаардлагатай ус цаг уур, орчны үзүүлэлтүүдийн орон зай, цаг хугацааны өөрчлөлтийн үнэлгээ;

7.2.4.улсын сүлжээн дэх станцын нягтрал, тоо хэмжээ, байршил, төлөвлөлтийн зураг, станцын жагсаалт, станц тус бүрийн ажиглалтын хөтөлбөрийг тодорхойлох;

7.2.5.ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх нөөц бололцоо, замын зураг, шийдлүүдийг тодорхойлох.

7.3.Улсын сүлжээний ерөнхий төлөвлөгөөг 10 жилээр төлөвлөнө. Шаардлагатай тохиолдолд хоёр жилд нэг удаа тодотгож болно.

8 дугаар зүйл.Улсын сүлжээний станц

8.1.Улсын сүлжээний станц нь дараах төрөлтэй байна:

8.1.1.цаг уурын станц;

8.1.2.дээд агаар мандлын цаг уурын станц;

8.1.3.цаг уурын радарын станц, агро цаг уурын станц;

8.1.4.ус судлалын станц;

8.1.5.хур тунадас хэмжих станц;

8.1.6.аянгын байрлал илрүүлэх станц;

8.1.7.бусад.

8.2.Улсын сүлжээний станцыг ерөнхий төлөвлөгөөний дагуу байгуулна.

8.3.Улсын сүлжээнд хамаарах станц төрийн өмч байна.

8.4.Улсын сүлжээнд хамаарах станцыг доор дурдсанаас бусад тохиолдолд нүүлгэн шилжүүлэхийг хориглоно:

8.4.1.гамшгийн улмаас эвдэрч, сэргээх боломжгүй болсон;

8.4.2.батлан хамгаалах, аюулгүй байдлын зорилгоор;

8.4.3.нийгэм, эдийн засгийн хөгжлийн чухал төслийн бүс нутагт байрладаг;

8.4.4.шинжилгээний талбайн стандартыг ноцтой зөрчсөн, эсхүл байгалийн нөхцөл байдлын нөлөөгөөр ажиглалт хийхэд хангалттай техникийн нөхцөлгүй болсон;

8.4.5.шинжилгээний талбайн мэдээлэл, өгөгдөл нь орчныг төлөөлөх чадваргүй болсон;

8.5.Станцыг нүүлгэн шилжүүлэх шийдвэрийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргах бөгөөд станцын шинэ байршил нь ажиглалт, хэмжилтийн шаардлага хангасан байна.

8.6.Станцыг улсын сүлжээний ерөнхий төлөвлөгөөнөөс хассан буюу ажиглалт хийх техникийн нөхцөлийг хангахгүй болсон, эсхүл нүүлгэн шилжүүлэх боломжгүй болсон тохиолдолд байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнийн шийдвэрээр зогсооно.

8.7.Станцын зэрэглэлийг хэмжих хэрэгслийн тоо хэмжээ, хөтөлбөр, үйл ажиллагааны хүрээг харгалзан ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно. (ТЗБ)

9 дүгээр зүйл. Ус цаг уур, орчны ажиглалт, хэмжилт

9.1.Ус цаг уур, орчны ажиглалт, хэмжилтийг техникийн заавар, хөтөлбөрийн дагуу үнэн зөв, тасралтгүй, шуурхай явуулна.

9.2.Ажиглалт, хэмжилтийн үр дүн нь станцын байрлаж буй нутаг дэвсгэрийн ус цаг уурын үзэгдлийн бодит байдал, байгалийн нөхцөл байдлыг бодитойгоор тусгаж, төлөөлөх байдлыг хангасан байна.

9.3.Ус цаг уур, орчны ажиглалт, хэмжилтийн хөтөлбөрийг станцын төрөл тус бүрээр байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно. ТЗБ

10 дугаар зүйл. Шинжилгээний талбай

10.1.Ус цаг уур, орчны ажиглалт, хэмжилт хийхэд зориулсан шинжилгээний талбай нь тусгайлан сонгон авч төхөөрөмжилсөн, хашаалсан, эсхүл өөр бусад байдлаар тэмдэглэж заагласан улсын тусгай хэрэгцээний газар байна.

10.2.Шинжилгээний талбайн орчноо төлөөлөх чадварыг хадгалах зорилгоор уг талбайн байршлыг улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгасан байна.

10.3.Шинжилгээний талбайд Дэлхийн цаг уурын байгууллагын стандартыг дагаж мөрдөнө.

10.4.Шинжилгээний талбайд зориулалтын бус багаж төхөөрөмж, бусад зүйл байрлуулахыг хориглоно.

10.5.Шинжилгээний талбайгаас гадагш 100 метрийн дотор хамгаалалтын бүс тогтооно.

10.6.Энэ хуулийн 10.5-д заасан хамгаалалтын бүсэд ажиглалт, хэмжилт хийхэд саад учруулахуйц барилга өндөрлөг байгууламж барих, мод тарих, зам гаргах шинжилгээний талбайн орчноо төлөөлөх чадварт нөлөөлөх бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

УС, ЦАГ УУР, ОРЧНЫ УРЬДЧИЛСАН МЭДЭЭ, СЭРЭМЖЛҮҮЛЭГ

11 дүгээр зүйл. Ус цаг уур, орчны урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлгийн ангилал, төрөл, хугацаа

11.1.Ус цаг уур, орчны урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг дараах ангилалтай байна:

- 11.1.1. нийтийн хэрэгцээний мэдээ;
- 11.1.2. тусгай хэрэгцээний мэдээ.

11.2. Энэ хуулийн 11.1.2-т заасан тусгай хэрэгцээний мэдээний нэр төрлийг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

11.3. Ус цаг уур, орчны урьдчилсан мэдээ дараах төрөлтэй байна:

11.3.1. цаг агаарын урьдчилсан мэдээ;

11.3.2. цаг агаарын урьдчилсан төлөв;

11.3.3. ус цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн урьдчилсан мэдээ буюу сэрэмжлүүлэг;

11.3.4. уур амьсгал, ус, орчны нөөцийн урьдчилсан мэдээ.

Органы бичиглэл
талаарх мэдээ
хаана байгаа
вс? үзэгдлийн
дараах
мэдээ.

11.4. Ус цаг уур, орчны сэрэмжлүүлэг дараах төрөлтэй байна:

11.4.1. анхааруулах мэдээ;

11.4.2. сэрэмжлүүлэх мэдээ;

11.4.3. урьдчилан сэргийлэх мэдээ.

11.4. Энэ хуулийн 11.4.2-т заасан анхааруулах мэдээний төрөл хамаарах цаг агаарын үзэгдлийн жагсаалтыг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

11.5. Хөдөө аж ахуй болон эдийн засгийн бусад салбарын хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учруулж болзошгүй цаг агаарын үзэгдлийг хор хөнөөлийнх нь байдлаар аюултай болон гамшигт үзэгдэл гэж ангилна. /Бэлтгэл хамгаалах тухай хуульд заасанхыг дахь үзэгдэл юу?

11.6. Энэ хуулийн 11.4.3 болон 11.4.4-т заасан мэдээний төрөлд хамаарах ус цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн жагсаалтыг Засгийн газар батална.

11.7. Ус цаг уурын урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэх мэдээний хугацаа:

11.7.1. хэт богино хугацаа;

11.7.2. богино хугацаа;

11.7.3. дунд хугацаа;

11.7.4. урт хугацаа;

11.7.5. бусад хугацаа.

төрийн газар юу? /

11.8. Ус цаг уурын урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг нь нийгэм эдийн засгийн салбарууд, иргэдийн ам нас, эд хөрөнгөд үзүүлэх нөлөөллийг агуулсан байна.

11.9. Ус цаг уурын урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэгт урьдчилан сэргийлэх зорилгоор авах арга хэмжээний зөвлөмжийг тусгаж болно. /агаар хортон үеийн бс.

11.10 Сэрэмжлүүлэгийн төрөл, үзэгдлийн төрөл, нөлөөлөл тус бүр тохирох арга хэмжээний жагсаалтыг Онцгой байдлыг асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага боловсруулан, Засгийн газраар батлуулан улс орны хэмжээнд мөрдөнө.

хасах эсвэл нийлүүлэх

12 дугаар зүйл. Ус цаг уур, орчны урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг

тайм?

12.1. Ус цаг уурын урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг болон орчны чанарын талаарх мэдээллийг ус цаг уур, орчны шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гаргана.

12.2. Ус цаг уур, орчны урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг гаргах үйл ажиллагаанд дараах зүйл хамаарна:

12.2.1. ус цаг уур, орчин болон уур амьсгалын өөрчлөлтийн хяналт шинжилгээний холбогдох мэдээ, мэдээллийг улсын хэмжээнд болон дэлхийн бүс нутаг, дэлхийн хэмжээнд цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, хадгалах;

12.2.2. хэрэглэгчийг ус цаг уур, орчны урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг мэдээллээр хангах;

12.2.3. ус цаг уур, орчны урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлгийн чанарын үнэлгээ.

12.3. Ус цаг уур, орчны урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг нь техникийн заавар журам, мэргэжлийн үйл ажиллагаанд нийцсэн байна.

12.4. Ус цаг уурын урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлгийг ус цаг уурын үзэгдлийн хөгжлийн явцтай уялдуулан тогтмол, шуурхай шинэчилж, хэрэглэхэд хялбар, ойлгомжтой гаргана.

13 дугаар зүйл. Ус цаг уур, орчны урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлгийг дамжуулах

13.1. Энэ хуулийн 21.1-д заасан мэдээг нэгтгэж олон улсын цаг уурын харилцаа холбооны сүлжээнд оруулах, уг сүлжээнээс Монгол Улсад шаардагдах мэдээллийг хүлээн авахад дотоодын болон олон улсын холбооны суваг ашиглана. Уг сувгаар газар хөдлөл, химийн болон цөмийн осол, иргэний агаарын тээврийн нислэгт зориулсан цаг уурын мэдээ зэрэг бусад шуурхай мэдээг дамжуулж болно.

13.2. Энэ хуулийн 21.1-д заасан мэдээг харилцаа холбооны байгууллага хяналтын хугацаанд саадгүй дамжуулна.

13.3. Цаг агаарын аюултай үзэгдлээс сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээг харилцаа холбооны хэрэгслээр дамжуулан онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллагад шуурхай дамжуулна. таа орой болгох?

13.4. Цаг агаарын гамшигт үзэгдлийн талаарх урьдчилан сэргийлэх мэдээг Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журамд заасны дагуу дамжуулна.

13.5. Цаг агаарын аюултай үзэгдлээс сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээг харилцаа холбооны байгууллага өмчийн хэлбэр харгалзахгүйгээр тэргүүн ээлжинд шуурхай дамжуулах үүрэгтэй.

13.6. Цаг агаарын аюултай үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээг зарласан, урьдчилан зарлаагүй боловч аюултай үзэгдэл эхэлсэн, эсхүл сэрэмжлүүлэх мэдээнд дурдсан үзэгдэл нь аюулын хэмжээнд хүрэхээр болсон үед аймаг, нийслэлийн ус цаг уур, орчны шинжилгээний төв нь сум, дүүргүүдэд уг мэдээг

хотом

яаралтай дамжуулна. Сум, дүүргийн сүлжээний станц, түүний ажилтан нь сум, дүүргийн Засаг дарга болон түүнийг орлох албан тушаалтанд холбоо, мэдээллийн бүх хэрэгслээр шуурхай хүргэнэ.

13.7. Иргэд хүн ам, байгаль орчинд ноцтой нөлөөлөх аюулт үзэгдэл, гамшиг тохиолдсон буюу тохиолдох нөхцөл бүрдсэн тухай ус цаг уур, орчны шинжилгээний аль ч нэгжид яаралтай мэдээлэх үүрэгтэй. ?

13.8. Гэнэтийн аюул, үйлдвэрлэлийн ослын үед нийтэд мэдээлэх орчны бохирдлын сэрэмжлүүлэх мэдээний жагсаалтыг Засгийн газар батална.

14 дүгээр зүйл. Ус цаг уур, орчны урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлгээр хэрэглэгчийг хангах

14.1. Ус цаг уур, орчны урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлгийг аймаг, бүс нутаг, улс орны хэмжээнд харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээнэ.

14.2. Урьдчилан сэргийлэх мэдээг харилцаа холбоо болон хэвлэл мэдээллийн байгууллага түүнийг хүлээн авснаас хойш 15 минутын дотор тусгай дуут болон дүрсийн дохиотойгоор улаан өнгөөр нийтэд үнэ төлбөргүйгээр шуурхай мэдээлэх үүрэгтэй.

14.3. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албаны баталгаажуулаагүй урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлгийг олон нийтэд түгээх, худал мэдээлэл тараахыг хориглоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

15 дугаар зүйл. Уур амьсгалын өөрчлөлтийн хяналт шинжилгээ

15.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага уур амьсгалын өөрчлөлтийг хянаж, үнэлж, ирээдүйн төлөв байдал, чиг хандлагыг тодорхойлно.

15.2. Уур амьсгалын өөрчлөлтийн хяналт, шинжилгээний ажлыг улсын сүлжээг ашиглан гүйцэтгэнэ.

15.3. Уур амьсгалын өөрчлөлтийн хяналт шинжилгээг шинжлэх ухааны байгууллага, их сургуулиудын дэргэдэх эрдэм шинжилгээний бусад байгууллагатай хамтран гүйцэтгэнэ. ?

16 дугаар зүйл. Уур амьсгалын өөрчлөлтийн хяналт, шинжилгээний агуулга

16.1. Уур амьсгалын өөрчлөлтийн хяналт шинжилгээ дараах агуулгаас бүрдэнэ: ?

16.1.1. улсын сүлжээний станцуудад хийсэн ус цаг уурын ажиглалт хэмжилтийн мэдээ, холбогдох мэдээллийг цуглуулах;

16.1.2. уур амьсгалын өөрчлөлтийн хяналт шинжилгээний мэдээллийн сан байгуулах, удирдах, ашиглах;

16.1.3.үнэлгээ, дүн шинжилгээ хийх;

16.1.4.уур амьсгалын өөрчлөлтийн хувилбаруудыг боловсруулах.

17 дугаар зүйл.Уур амьсгалын өөрчлөлтийн хяналт, шинжилгээний мэдээллийн сан

17.1.Уур амьсгалын өөрчлөлтийн хяналт, шинжилгээний мэдээллийн сан нь уур амьсгалын өөрчлөлтийн хяналт, шинжилгээний талаарх бүх мэдээ, мэдээлэлд бүрдүүлэх бөгөөд энэ хуулийн 22 дүгээр зүйлд заасан мэдээллийн сангийн бүрэлдэхүүн хэсэг байна.

17.2.Энэ хуулийн 16.1.2-т заасан мэдээллийн сан дараах зүйлээс бүрдэнэ:

17.2.1.уур амьсгалын үндсэн мэдээлэл;

17.2.2.холбогдох байгууллагын бүртгэл, мэдээлэл;

17.2.3.хүлэмжийн хийн тооллогын өгөгдөл, мэдээлэл;

17.2.4.уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий болон нэн өртөмтгий байгалийн нөөц, байгалийн тогтолцоо, бүрэлдэхүүн хэсгийн ангиллын өгөгдөл, мэдээлэл;

17.2.5.уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг байдал болон эрсдэлийн үнэлгээний мэдээ, тайлан;

17.2.6.хүлэмжийн хийн ялгарлын бууралт, шингээлтийн өгөгдөл, мэдээлэл;

17.2.7.энэ хуульд заасан карбон зах зээлийн бүртгэлтэй холбоотой мэдээлэл;

17.2.8. хуульд заасан бусад.

17.3.Уур амьсгалын өөрчлөлийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх харилцааг Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль болон Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар зохицуулна.

18 дугаар зүйл.Үнэлгээ, дүн шинжилгээ

18.1.Үнэлгээ, дүн шинжилгээ агуулга:

18.1.1.өөрийн орны уур амьсгалын өнөөгийн байдал;

18.1.2.улсын уур амьсгалын өөрчлөлт, уур амьсгалын хэлбэлзэлийг түүхэн болон өмнөх үнэлгээний үетэй харьцуулж, олон улсын уур амьсгалын стандартай харьцуулах;

18.1.3.уур амьсгал, уур амьсгалын өөрчлөлтийн байгалийн нөөц, байгаль орчин, эко систем, амьдрах орчин, нийгэм эдийн засгийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөлөл;

18.1.4.уур амьсгалын өөрчлөлтийн хариу арга хэмжээний үр дүн;

18.1.5.уур амьсгалын өөрчлөлтийн хувилбаруудын зохистой байдлын түвшин, уур амьсгалын өөрчлөлтөд хариу үйлдэл үзүүлэхэд уур амьсгалын өөрчлөлтийн хувилбаруудыг ашиглах.

18.2.Уур амьсгалын үнэлгээний хугацаа 10 жил байна.

19 дүгээр зүйл.Уур амьсгалын өөрчлөлтийн хувилбарууд

19.1.Уур амьсгалын өөрчлөлтийн хувилбарын үндсэн агуулга:

19.1.1.уур амьсгалын өөрчлөлтийн шинж тэмдэг;

19.1.2.уур амьсгалын өөрчлөлтийн хувилбаруудын өмнөх үеийн үнэлгээний үр дүн;

19.1.3.температур, хур тунадас, чийгшил болон бусад ус цаг уурын хүчин зүйлсийн ирээдүйн өөрчлөлт;

19.1.4.бусад холбогдох агуулга.

19.2.Уур амьсгалын өөрчлөлтийн хувилбаруудыг боловсруулах, өөрчлөх хугацаа нь 5 жил байна.

20 дугаар зүйл.Орчны хяналт шинжилгээ

20.1.Орчны хяналт шинжилгээ нь байгаль орчны төлөв байдлын хяналт шинжилгээ, агаарын чанарын хяналт шинжилгээ, усны хяналт шинжилгээ, хөрсний доройтол, цөлжилтийн төлөв байдлын судалгаа, дүгнэлтээс бүрдэнэ.

20.2.Агаарын чанарын хяналт шинжилгээг Агаарын тухай, усны хяналт шинжилгээг Усны тухай, хөрсний доройтол, цөлжилтийн төлөв байдлын судалгаа, дүгнэлтийг Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулиар тус тус зохицуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ УС ЦАГ УУР, УУР АМЬСГАЛ, ОРЧНЫ МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ, САН, АРХИВ

21 дугаар зүйл.Ус цаг уур, уур амьсгал, орчны мэдээ, мэдээлэл

21.1.Ус цаг уур, уур амьсгал, орчны мэдээ, мэдээлэл дараах агуулгаас бүрдэнэ:

21.1.1.ус цаг уур, уур амьсгал, орчны ажиглалт хэмжилтийн мэдээ, тоо баримт;

↑

21.1.2.гадаад улс, олон улсын байгууллагаас авсан мэдээ, тоо баримт;

21.1.3.хиймэл дагуулын болон газрын зураг, холбогдох гэрэл зураг;

21.1.4.ус цаг уур, орчны урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг, төлөв байдлын тойм;

↑

21.1.5.ус цаг уурын станц, хэмжих хэрэгслийн техникийн бүртгэл;

21.1.6.ус цаг уурын шинжлэх ухааны судалгаа, төсөл хөтөлбөрийн үр дүн;

↑

21.1.7.агаарын төлөв байдал, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа

↑

21.1.8.техникийн заавар, үйл ажиллагааны журам.

22 дугаар зүйл. Ус цаг уур, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийн сан

22.1. Ус цаг уур, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийг стандартад нийцүүлэн, дамжуулах, шинэчлэх, удирдах, ашиглах зориулалт бүхий цахим сантай байна.

22.2. Цахим сангийн ~~ажуулгүй~~ байдлыг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна.

22.2. Цахим сангийн мэдээлэл бүрдүүлэх, ашиглах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

23 дугаар зүйл. Ус цаг уур, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийн ашиглалт, хэрэглээ

23.1. Хэрэглэгч ус цаг уур, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийн сан, архивын мэдээллийг энэ хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу ашиглаж болно.

23.2. Хэрэглэгчийн ашиглаж буй ус цаг уур, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийн гарал үүсэл нь тодорхой байх шаардлагатай бөгөөд ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага баталгаажуулсан байна.

23.3. Төрийн байгууллага хүсэлт тавьсан тохиолдолд ус цаг уур, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийн сан, архивын мэдээллийг төлбөргүй ашиглаж болно.

23.4. Энэ хуулийн 23.3-т заасаас бусад тохиолдолд ус цаг уур, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийн сан, архивын мэдээллийг ашиглахдаа хүн, хуулийн этгээд энэ хуульд заасан журмын дагуу үйлчилгээний хөлс төлнө.

23.5. Ус цаг уур, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийн сан, архиваас үзүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

23.6. Даатгалын байгууллагаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад даатгалын төлбөр олгохдоо тухайн үеийн ус цаг уур, орчны нөхцөл байдлын тухай ус цаг уур, орчны хяналт шинжилгээний байгууллагаас ~~гаргасан~~ тодорхойлолтыг үндэслэн олгоно.

24 дүгээр зүйл. Ус цаг уур, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийн архив

24.1. Ус цаг уур, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийн архив нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд заасан төрөлжсөн архив байна.

24.2. Ус цаг уур, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийг ~~турт~~ хугацаанд хадгалж, архивлана.

24.3. Ус цаг уур, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийг архивт оруулахаас ~~өмнө~~ ус цаг уурын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага чанарыг шалгаж, ангилна.

24.4. Ус цаг уур, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийн нууцын холбогдолтой ^{тай холбоотой бөгөөд} архивын баримтыг Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасны дагуу зохицуулна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ
АГААРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЦАГ АГААРТ
ЗОРИУДААР НӨЛӨӨЛӨХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

25 дугаар зүйл. Агаарын төлөв байдал, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа

25.1. Агаарын төлөв байдал, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг дараах зорилгоор тодорхой бүс нутагт тодорхой хугацаанд хийж болно:

- 25.1.1. хур тунадас нэмэгдүүлэх;
- 25.1.2. хур тунадасын эрчмийг багасгах эсхүл сэргийлэх;
- 25.1.3. манангийн эрчмийг сарниулах буюу багасгах.

25.2. Агаарын төлөв байдал, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг батлагдсан төлөвлөгөөний дагуу ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гүйцэтгэнэ. ^{Хамгаалалтын захиргаа, тусламтас бэхлэлт} ^{Хамгаалалтын захиргаа, тусламтас бэхлэлт}

25.3. Энэ хуулийн 25.2-т заасан төлөвлөгөөг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

25.4. Энэ хуулийн 25.2-т заасан төлөвлөгөө дараах агуулгатай байна:

25.4.1. энэ хуулийн 25.1-д заасан агаарын төлөв байдал, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны зорилго;

25.4.2. агаарын төлөв байдал, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа явуулах талбайн мэдээлэл;

25.4.3. агаарын төлөв байдал, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа явуулах ойролцоолсон хугацаа;

25.4.4. агаарын төлөв байдал, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны төрөл, арга хэмжээ;

25.4.5. аюулгүй байдлыг хангах агаарын төлөв байдал, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны сөрөг нөлөөллийг багасгах төлөвлөгөө.

25.5. Агаарын төлөв байдал, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа нь агаарын төлөв байдал, уур амьсгалд сөрөг нөлөөлөхгүй, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаа, улсын батлан хамгаалах, аюулгүй байдалд саад учруулахгүй, сөрөг нөлөө үзүүлэхгүй байвал зохино.

25.6. Агаарын төлөв байдал, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа явуулах тохиолдолд тухайн орон нутгийн оршин суугчдад мэдээлнэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ
УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ТӨРИЙН БОЛОН
НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

26 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

26.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаар Улсын Их Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

26.1.1. ус цаг уур, орчны хяналт шинжилгээтэй холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

26.1.2. энэ хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг баталж, зарцуулалтад хяналт тавих;

26.1.3. хуульд заасан бусад бүрэн эрх.

27 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

27.1. Засгийн газар ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

27.1.1. ус цаг уур, орчны мэдээлэл, уур амьсгалын нөөцийг нийгэм, эдийн засгийн хөгжилд бүрэн дүүрэн ашиглах нөхцөлийг хангах;

27.1.2. ус цаг уур, орчны мэдээллийг ашиглах, аюул болон орчны ноцтой бохирдлоос сэргийлэх тогтолцоог бүрдүүлэх;

27.1.3. ус цаг уур, орчны хяналт шинжилгээний үйл ажиллагаанд шаардагдах төсвийн төслийг боловсруулж батлуулах;

27.1.4. ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаарх дүрэм, журмыг батлах;

27.1.5. улсын сүлжээний ерөнхий төлөвлөгөөг батлах;

27.1.6. хуульд заасан бусад бүрэн эрх.

28 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

28.1. Төрийн захиргааны төв байгууллага ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

28.1.1. ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаарх төрийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих;

28.1.2. тусгай хэрэгцээний мэдээний төрөл, үйлчилгээний төлбөрийн хэмжээг батлах;

28.1.3. агаарын төлөв байдал, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хяналт тавих.

28.1.4. ус цаг уур, орчны хяналт шинжилгээтэй холбогдсон дүрэм, журам, аргачлал, зааврыг батлах;

28.1.5. улсын сүлжээний станцыг байгуулах, нүүлгэн шилжүүлэх, үйл ажиллагааг зогсоох;

28.1.6.ус цаг уур, орчны ажиглалт, хэмжилтийн хөтөлбөрийг станцын төрөл тус бүрээр тогтоох;

28.1.7.цахим сангийн мэдээлэл бүрдүүлэх, ашиглах журам батлах;

28.1.8.хуульд заасан бусад бүрэн эрх.

29 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын эрх, үүрэг

29.1. Аймаг нийслэл, сум дүүргийн Засаг дарга ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаар дараах эрх, үүрэгтэй:

29.1.1. ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаарх хууль тогтоомж, Засгийн газар, бусад эрх бүхий байгууллагын шийдвэрийн биелэлтийг хангах;

29.1.2. нутаг дэвсгэрийнхээ ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний станцын тасралтгүй ажиллах нөхцлийг бүрдүүлэх;

29.1.3. ус цаг уур, орчны мэдээллээр нутаг дэвсгэрийнхээ хэрэглэгчийг шуурхай хангах, аюул болон орчны ноцтой бохирдлоос сэргийлэх ажлыг зохион байгуулах;

29.1.4. нутаг дэвсгэрийнхээ ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талбай, тоног төхөөрөмжийг хамгаалах арга хэмжээ авах.

НАЙМДУГААР БҮЛЭГ УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ТОГТОЛЦОО

30 дугаар зүйл. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албаны тогтолцоо

30.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албаны тогтолцоо нь ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл/сум, баг, ийн ус цаг уур, орчны шинжилгээний төв, ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн, байгаль орчны хэмжил зүйн лаборатори, нислэгийн цаг уурын төвөөс бүрдэнэ.

30.2. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний алба нь өөрийн харьяанд эрдэм шинжилгээ, туршилт үйлдвэрлэл болон хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, баталгаажуулалт хийх үүрэг бүхий мэргэжлийн нэгж/төв/-тэй байж болно.

30.3. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний алба нь мэргэжлийн, нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байна.

30.4. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргыг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18⁴.2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Засгийн газар томилж, чөлөөлнө.

30.5. Энэ хуулийн 30.1-д заасан албадын удирдлага/дарга, захирал/-ыг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, ажилтанг тухайн байгууллага удирдлага томилж, чөлөөлнө.

30.6.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албаны төсвийг улсын төсөвт тусган санхүүжүүлнэ.

31 дүгээр зүйл.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага

31.1.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах үндсэн чиг үүрэгтэй:

31.1.1.ус цаг уур, орчны хяналт шинжилгээний хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

31.1.2.ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээг удирдан зохион байгуулах;

31.1.3.ус цаг уурын ажиглалт, хэмжилт, дүн шинжилгээ, орчны хяналт шинжилгээ, уур амьсгалын өөрчлөлтийн хяналт шинжилгээ хийх;

31.1.4.хэрэглэгчийг ус цаг уур, орчны урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг мэдээллээр шуурхай хангах;

31.1.5.шаардлагатай тохиолдолд агаарын төлөв байдал, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг гүйцэтгэх;

31.1.6.ус цаг уур, орчны хяналт шинжилгээний судалгаа, шинжилгээний ажил хийх;

31.1.7.ус цаг уур, орчны хяналт шинжилгээний хэмжлийн нэгдмэл байдал, мэдээллийн стандартчиллыг хангах;

31.1.8.ус цаг уур, орчны төлөв байдлын талаар мэргэжлийн дүгнэлт гаргах;

31.1.9.ус цаг уур, орчны хяналт шинжилгээнд орчин үеийн дэвшилтэд техник, технологи нэвтрүүлэхэд чиглэсэн эрдэм шинжилгээ, туршилтын ажлыг зохион байгуулах;

31.1.10.салбарынхаа хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг нь хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

31.1.11.ус цаг уур, орчны шинжилгээний мэдээллийг цуглуулах, солилцоонд гаргахад олон улсын мэдээллийн суваг ашиглах асуудлыг зохицуулах, Дэлхийн цаг уурын байгууллагын конвенцийн хүрээнд Монгол Улсын хүлээсэн үүргийг биелүүлэх;

31.1.12.ус цаг уур, орчны хяналт шинжилгээний үйл ажиллагааны талаар олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх.

31.2.Энэ хуулийн 30.2-т заасан харьяа байгууллагын бүтэц, орон тооны дээд хязгаар, дүрмийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

32 дугаар зүйл.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албаны ажилтны эрх, үүрэг, нийгмийн баталгаа

32.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албаны ажилтан дараах эрхтэй:

32.1.1. эрүүл, аюулгүй, стандартын шаардлага хангасан орчин, нөхцөлд хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах;

32.1.2. гүйцэтгэж байгаа албан үүргийн шинж байдлаас хамааран тусгай зориулалтын хувцас, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдах;

32.1.3. жил бүр холбогдох хууль тогтоомжийн дагуу эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах;

32.1.4. хууль тогтоомжид заасны дагуу тусламж авах, хөнгөлөлт эдлэх, нийгмийн баталгаагаар хангагдах;

32.1.5. хуульд заасан бусад.

33.2. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албаны ажилтан дараах үүрэгтэй:

33.2.1. ус цаг уур, орчны ажиглалт хэмжилтийг техникийн заавар, хөтөлбөрийн дагуу үнэн зөв хийж, үр дүнг шуухай мэдээлэх;

33.2.2. холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, аргачлалыг чанд сахин мөрдөх;

33.2.3. мэргэжлийн ёс зүйг чандлан сахиж, нэр төрийг эрхэмлэх; ?

33.2.4. улс төрөөс ангид байж, хуулиар зөвшөөрснөөс бусад улс төрийн аливаа үйл ажиллагаанд оролцохгүй байх;

33.2.5. мэргэжлийн ур чадвараа байнга дээшлүүлэх;

33.2.6. хуульд заасан бусад.

33.3. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албаны ажилтан дараах нийгмийн баталгаагаар хангагдана:

33.3.1. ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албанд 20 ба түүнээс дээш жил ажилласан ажилтанд өндөр насны тэтгэвэр тогтоолгоход Төрийн албаны тухай хуульд заасны дагуу нэг удаагийн буцалтгүй тусламж олгох;

33.3.2. орон нутагт ажиллаж байгаа ажилтанд эхний тав дахь жил болон дараагийн гурав дахь жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг олгох;

33.3.3. гамшгийн үед ажилласан ажилтанд ажилласан хугацааны цалин хөлсийг нь гурав дахин нэмэгдүүлж олгох;

33.3.4. албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан тохиолдолд таван жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн ажилтны сарын үндсэн цалингийн дунджаар тооцож түүний гэр бүлд нэг удаа олгох;

33.3.5.хөдөлмөрийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэл бүхий болон тэдгээртэй адилтгах эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа ажилтанд мөнгөн урамшуулал олгох;

33.3.6.амь нас, эрүүл мэнд хохирох өндөр эрсдэлтэй нөхцөлд үүрэг гүйцэтгэх тохиолдолд мөнгөн урамшуулал олгох;

33.3.7.гэнэтийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд заавал даатгуулах.

33.4.Энэ хуулийн 33.3.5, 33.3.6-д заасан мөнгөн урамшуулал олгох журмыг санхүү, төсвийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

33.5.Ажилтан албан үүргээ зохих журмын дагуу биелүүлэх явцдаа бусдын эд хөрөнгөд хохирол учруулсан бол тухайн хохирлыг төр хариуцна.

33.6.Энэ хуулийн 33.3-т заасан нийгмийн баталгааг олгоход шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ УС ЦАГ УУР, ОРЧНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

34 дугаар зүйл.Ус цаг уур, орчны үйлчилгээ

34.1.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах үйлчилгээг үзүүлнэ:

34.1.1.нийтийн хэрэгцээний мэдээгээр хэрэглэгчийг хангах;

34.1.2.тусгай хэрэгцээний мэдээгээр хангах;

34.1.3.агаарын төлөв байдал, цаг агаарт зориудаараар нөлөөлөх;

34.1.4.нислэгийн цаг уурын үйлчилгээ;

34.1.5.хэмжилт, ажиглалтын багаж хэрэслийг баталгаажуулах.

34.2.Энэ хуулийн 34.1.1-т заасан нийтийн хэрэгцээний мэдээгээр хэрэглэгчийг хангах үйлчилгээг үндсэн чиг үүргийн хүрээнд үнэ төлбөргүй үзүүлнэ.

34.3.Энэ хуулийн 34.1.2- 34.1.5-д заасан үйлчилгээг хэрэглэгчийн хүсэлтэд үндэслэн төлбөртэй үзүүлнэ.

34.4.Энэ хуулийн 34.1.2, 34.1.4 болон 34.1.5-д заасан үйлчилгээний төлбөрийн хэмжээг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

34.5.Энэ хуулийн 34.1.4.-т заасан нисэхийн цаг уурын үйлчилгээний төлбөрийн хэмжээг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран Иргэний нисэхийн тухай хуулийн 5.1.2-т заасан навигацгийн үйлчилгээний хураамжийн хэмжээний зохих хувиар тогтооно.

34.6.Нислэгийн цаг уурын үйлчилгээг нисэхийн олон улсын гэрээ, олон улсын иргэний нисэхийн байгууллагын баримт бичиг нийцсэн нислэгийн цаг уурын

14345-00
17

~~үйлчилгээг нислэгийн үйл ажиллагааны болон нислэгийн цаг уурын шаардлага хангасан заавар, журмын дагуу үзүүлнэ.~~

34.7. Энэ хуулийн 34.6-д заасан заавар, журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

35 дугаар зүйл. Хувийн ус цаг уурын үйлчилгээ

Зөвшөөрлийн тухай хууль

35.1. Энэ хуульд заасан ус цаг уурын үйлчилгээ /цаашид "хувийн ус цаг уурын үйлчилгээ" гэх/-г Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлж болно.

35.2. *Хувийн ус цаг уурын үйлчилгээг дараах үйл ажиллагаа хангана. Үүнд:*

35.2. Тусгай зөвшөөрлийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн 5 жилийн хугацаагаар олгоно.

*- Хиймэл туррам шээх
- Дөн шээх
- ЦАЗН
- Радарын дон...*

35.3. Тусгай зөвшөөрөл хүсэгч нь дараах бичиг баримтыг ирүүлнэ:

*- Хс, цаг уурын
Амлан
доо тэдгээрийн дүгнэлт*

35.3.1. тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл;

35.3.2. улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

35.3.3. аж ахуйн нэгжийн танилцуулга;

35.3.4. хувьцаа эзэмшигчийн нэр, хаяг, эрхэлж байсан болон эрхэлж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээний танилцуулга;

35.3.5. аж ахуйн нэгжийг удирдах, төлөөлөх эрх бүхий этгээд болон эцсийн өмчлөгчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хаяг, иргэний бүртгэлийн дугаар, намтар, гэмт хэрэгт холбогдож байсан эсэх талаар тодорхойлолт;

35.3.6. хүний нөөц, энэ хуулийн 37.7.3-т шаардлагыг хангасан талаарх мэдээлэл;

36.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн хугацаанд тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчөөгүй, зөрчил гаргаагүй бол эрх бүхий этгээд тусгай зөвшөөрлийг анх олгосон хугацаагаар сунгана.

36.5. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахдаа Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

36.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн хугацаанд тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, үүргээ ноцтой зөрчсөн, эсхүл хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг тогтоосон хугацаанд арилгаагүй бол тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахгүй.

37.7. Хувийн ус цаг уурын үйлчилгээ үзүүлэгч дараах шаардлагыг хангаж ажиллана:

37.7.1. хувийн ус цаг уурын үйлчилгээ үзүүлэх санхүүгийн чадамжтай байх, эх үүсвэр нь хууль ёсны байх;

37.7.2. хувийн ус цаг уурын үйлчилгээ үзүүлэхэд ашиглах мэдээлэл, технологийн дэд бүтцийн тасралтгүй, найдвартай ажиллагаа, аюулгүй байдлыг хангах;

37.7.3.холбогдох мэргэжлээр мэргэшсэн, туршлагатай хүний нөөцтэй байх.

37.8.Тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрийн боловсруулсан ус цаг уур, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийг энэ хуулийн 22.1-д заасан цахим санд нийлүүлнэ.

↳ зохих тохиргоогоор 37.9 Төлбөрийн хайрцаг бодогдсон тохиолдолд.

37.9.Тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрийн гаргасан ус цаг уур, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага баталгаажуулна.

37.10.Тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сунгах, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.

АРАВДУГААР БҮЛЭГ БУСАД

38 дугаар зүйл.Олон улсын хамтын ажиллагаа

38.1.Олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг Монгол Улсын хууль тогтоожид нийцүүлэн хэрэгжүүлнэ:

38.1.1.ус цаг уур, уур амьсгал, орчны мэдээ, мэдээлэл, өгөгдөл, судалгааг олон улсын байгууллага, гадаад улстай харилцан солилцох;

38.1.2.бүс нутгийн болон дэлхийн хамтын ажиллагааны хөтөлбөрт оролцох;

38.1.3.олон улсын байгууллага болон гадаад улс оронтой хамтран судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх;

38.1.4.боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх, бэлтгэх, харилцан солилцох.

39 дүгээр зүйл.Нийтэд сурталчилах

? (-)

39.1.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээ, уур амьсгалын өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлэл өгөх, ус цаг уурын урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг мэдээллийг үр дүнтэй ашиглах талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж болно.

40 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

40.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

40.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Гарын үсэг

Узга баримтлалын гол санаачилга
орчиндсон зохих тусгай
ногтлох

Дагах төсөл
2025-10-31
Зөвхөн албан хэрэгцээнд
Хувилбар 1

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5 дахь заалтын “байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай;” гэснийг “ус цаг уур, орчны ажиглалт, хэмжилтийн шинжилгээний талбай;” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Ус цаг уур, орчны хяналт шинжилгээ тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Дагах төсөл
2025-10-31
Зөвхөн албан хэрэгцээнд
Хувилбар 1

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн хүснэгтийн “Тусгай зөвшөөрөл” гэсэн хэсэгт “1.32.ус цаг уурын үйлчилгээ” гэж, мөн хэсгийн “Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд” гэсэн хэсэгт “Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Ус цаг уур, орчны хяналт шинжилгээ тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Дагах төсөл
2025-10-31
Зөвхөн албан хэрэгцээнд
Хувилбар 1

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд доор дурдсан агуулга бүхий 21.1.49 дэх заалт нэмсүгэй:

“21.1.49.ус цаг уурын үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгох, түүний хугацааг сунгахад _____төгрөг;”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Ус цаг уур, орчны хяналт шинжилгээ тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуулийн хуульд доор дурдсан агуулга бүхий 7.20 дугаар зүйл нэмсүгэй:

“7.20 дугаар зүйл. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль зөрчих

1. Ус цаг уур, орчны ажиглалт, хэмжилт хийхэд зориулсан шинжилгээний талбайд зориулалтын бус багаж төхөөрөмж, бусад зүйл байрлуулсан бол учирсан хохирлыг нөхөн төлүүлж, хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Ус цаг уур, орчны ажиглалт, хэмжилт хийхэд зориулсан шинжилгээний талбайгаас гадагш 100 метр доторх хамгаалалтын бүсэд ажиглалт, хэмжилт хийхэд саад учруулахуйц барилга, өндөрлөг байгууламж барьсан, эсхүл мод тарьсан, эсхүл зам гаргасан, эсхүл шинжилгээний талбайн орчноо төлөөлөх чадварт нөлөөлөх бусад үйл ажиллагаа явуулсан бол учирсан хохирлыг нөхөн төлүүлж, хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3. Улсын сүлжээнд хамаарах станцыг зохих шийдвэргүйгээр нүүлгэн шилжүүлсэн бол учирсан хохирлыг нөхөн төлүүлж, хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4. Цаг агаарын аюултай үзэгдлээс сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээг тэргүүн ээлжинд шуурхай дамжуулах үүргээ хэрэгжүүлээгүй харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5. Урьдчилан сэргийлэх мэдээг хүлээн авснаас хойш 15 минутын дотор тусгай дуут болон дүрсийн дохиотойгоор нийтэд үнэ төлбөргүйгээр шуурхай мэдээлэх үүргээ хэрэгжүүлээгүй харилцаа холбоо болон хэвлэл мэдээллийн байгууллагыг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албаны баталгаажуулаагүй урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэгийг олон нийтэд түгээсэн, худал мэдээлэл

тараасан бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.Хүн ам, байгаль орчинд ноцтой нөлөөлөх аюулт үзэгдэл, гамшиг тохиолдсон буюу тохиолдох нөхцөл бүрдсэн тухай мэдээлэх үүргээ биелүүлээгүй хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Ус цаг уур, орчны хяналт шинжилгээ тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Дагах төсөл
2025-10-31
Зөвхөн албан хэрэгцээнд
Хувилбар 1

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.8 дахь заалтын “7.19 дүгээр зүйлийн 1, 2, 3, 6, 10, 11 дэх хэсэг,” гэсний дараа “7.20 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсэг,” гэж, мөн зүйлийн 6.37 дахь заалтын “7.13 дугаар зүйлийн 13 дахь хэсэг,” гэсний дараа “7.20 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг,” гэж, мөн зүйлийн 6.50 дахь заалтын “6.30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг,” гэсний дараа “7.20 дугаа зүйлийн 4, 5 дахь хэсэг,” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Ус цаг уур, орчны хяналт шинжилгээ тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг